

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | |
|---|----|
| 1. Аудитын гэрчилгээ | 3 |
| 2. Аудитын тайлан..... | 4 |
| 2.1. Оршил | 4 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага..... | 4 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 5 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 6 |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 7 |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 7 |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ... | 8 |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл | 8 |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 8 |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 8 |
| 3. Менежментийн захидал..... | 9 |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 11 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 11 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 13 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 15 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 17 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 18 |
| 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан..... | 20 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 21 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ӨНӨР БҮЛ ХҮҮХДИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ М.ӨЛЗИЙЧИМЭГ ТАНАА

2020.08.27 № 06/617
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Өнөр бүл хүүхдийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Өнөр бүл хүүхдийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн зөв, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өнөр бүл хүүхдийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих, нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Өнөр бүл хүүхдийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал М.Өлзийчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой бодитоор оршин байхгүй хөрөнгүүдийг бүртгэлээс хасах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль, журмын шинэчлэлтүүдийг тусгах, худалдан авах ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулах, бараа материалыг зөв ангилж илэрхийлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өнөр бүл хүүхдийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 05-аас 2020 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Санхүүч-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Санхүүч-Аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 16 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Өнөр бүл хүүхдийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хүүхдийн эрхийг хүндлэн дээдэлж, оролцоонд тулгуурлан, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, амьдрах ухааны дадал, чадвар эзэмшүүлэх, урлаг, спортоор дамжуулан нийгэмшүүлэн, төлөвшүүлэх, хөгжүүлэх, хүүхэд бүрийг гэр бүлд дүйцэхүйц орчинд өсгөн хүмүүжүүлж, эерэг хандлагатай, бие хүн болгон төлөвшүүлэхэд оршино.

Өнөр бүл хүүхдийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүтэн өнчин,
- Эцэг эх байх эрх нь хязгаарлагдсан
- Эцэг эх нь хориход байгаа
- Эцэг эх нь сэтгэцийн өвчтэй
- Эцэг эх нь хөдөлмөрийн чадвараа 70 хувиас дээш алдсан иргэдийн зорилтот бүлгийн хүүхдүүдийг хүлээн авч үйлчилгээнд хамруулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд газрын төлбөрийн хэмжээтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт орсон.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5, 8 болон 29 дүгээр зүйлүүдэд нэмэлт, өөрчлөлт орсон.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Өнөр бүл хүүхдийн төвийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна.

Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар шинэчлэгдсэн анхан шатны бүртгэлийн маягт, заавар, Сангийн сайдын 2018 оны 100 тоот тушаалаар шинэчлэгдсэн нягтлан бодох бүртгэлийн маягтууд, Сангийн сайдын мөн оны 301 тоот тушаалаар шинэчлэгдсэн дотоод албан томилолтын зардлын хэмжээ зэргийг шинэчлэн тусгаагүй байна.

Өнөр бүл хүүхдийн төв нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Өнөр бүл хүүхдийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Өнөр бүл хүүхдийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн

10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,093,456.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 10,934.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 25,370.1 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь болгон авч үзсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Өнөр бүл хүүхдийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 66,035.1 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| | /мянган төгрөг/ | | |
|---|--------------------|--------------------|-----------------|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 2,966.3 | - | (2,966.3) |
| Бараа материал | 265,517.1 | 198,579.3 | 66,937.8 |
| Үндсэн хөрөнгө | 8,069,620.5 | 8,205,559.7 | 135,939.2 |
| Нийт хөрөнгө | 8,338,103.9 | 8,404,139.0 | 66,035.1 |
| Өр төлбөр | 227.5 | 20,591.0 | 20,363.5 |
| Засгийн газрын оролцоо | 1,746,814.0 | 1,746,814.0 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 3,692,468.4 | 3,753,254.5 | 60,786.2 |
| Өмнөх үеийн үр дүн | 3,692,468.4 | 3,707,582.8 | 15,114.5 |
| Тайлант үеийн үр дүн | - | 45,671.7 | (45,671.7) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,898,593.9 | 2,883,479.5 | (15,114.5) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 8,338,103.9 | 8,404,139.0 | 66,035.1 |

Ажиллагсдаас авах авлага барагдсанаар тайлант оны эцэст авлагагүй болсон. Бараа материал буурсан нь хүнсний материалын бууралтаас голлон шалтгаалжээ. Бараа материал дансанд 88,632.9 мянган төгрөгийн хүнсний материал, 91,503.8 мянган төгрөгийн хувцас хэрэглэл, 18,442.6 мянган төгрөгийн бичиг хэрэг, эм, боох материал, сэлбэг хэрэгсэл, шатах тослох материалууд байна.

Өр төлбөр 20,136.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 20,363.5 мянган төгрөг болсон. Энэ нь барилгын засварын ажлын үлдэгдэл санхүүжилттэй холбоотой үүссэн өглөг байна. 2019 онд дахин үнэлгээ хийсэн 2 тракторыг акталсантай холбоотойгоор дахин үнэлгээний зөрүү данс 15,114.4 мянган төгрөгөөр буурсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн урсгал зардалд 1,995,012.9 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулахад материаллаг дүнтэй хэлбэлзэл бүхий зардал гараагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,990,785.7 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь бараа, үйлчилгээний бусад зардлын хэмнэлтээс шалтгаалсан байна. Нийт зардлыг хөтөлбөр арга хэмжээгээр авч үзвэл: 97.1 хувь буюу 1,933,519.3 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалд /80101/, 0.6 хувь буюу 11,563.7 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд /80305/, 2.3 хувь буюу 45,702.6 мянган төгрөгийг урсгал шилжүүлгийн зардалд /80802/ тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсөв: Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 301 тоот тогтоолоор Өнөр бүл хүүхдийн төвийн цахилгааны гэмтлээс болж шатсан барилгын засварт зориулан улсын төсвөөс 488,400.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн байна. Засварын ажлын санхүүжилтийг олгохдоо 419,727.7 мянган төгрөгийг Өнөр бүл хүүхдийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан, үлдэгдэл 68,672.2 мянган төгрөгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас их засвар хийсэн “Юовоку” ХХК, “Их Даян Бүүвэй” ХХК, “Нойкрафт” ХХК-руу 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр шилжүүлэн олгосон байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар “Юовоку ХХК-д засварын ажлын үлдэгдэл санхүүжилтийн 15,599.7 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тус төвийн барилгад гал гарсантай холбогдуулан яаралтай арга хэмжээний санхүүжилтэнд 35,167.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 13,000.0 мянган төгрөг нийт 48,167.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 61,128.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 53,092.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 8,734.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, бусад асуудлаар 3 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 8,734.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 8,734.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр “Түмэн оньс” ХХК-тай 59,528.7 мянган төгрөгийн бараа материал /гутал, хувцас/ худалдан авах гэрээ байгуулсан боловч 86,668.7 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Гэрээний дүнг нийт 34.7 хувиар хэтрүүлэн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 34.1.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

2. Нэмэлт санхүүжилтийн 48,167.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн тайланг тусд нь тайлагнаагүй, төсөвт төвлөрүүлсэн 4,227.2 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 22.6.7 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Аудитын явцад залруулав.

3. “Олимпус спортинг гүүдс” ХХК-аас худалдан авсан гантель, гар бөмбөг, теннисний бөмбөг зэрэг 8 нэр төрлийн 384.4 мянган төгрөгийн, “Эгшиглэн” ХХК-аас авсан 313.0 мянган төгрөгийн хөгжмийн сэлбэг хэрэгслийг бичиг хэргийн материал дансанд бүртгэсэн. Энэ нь УСНББОУС 12 *Бараа материал*, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Аудитын явцад залруулав.

Аудитаар илэрсэн бусад алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Өнөр бүл хүүхдийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагаас баталсан төсөв, гүйцэтгэлийн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7,073.8 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоосныг бүрэн барагдуулж, 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өнөр бүл хүүхдийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 8,734.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 25,370.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: 1982 онд ашиглалтанд орсон, тус төвийн тайланд бүртгэлтэй (бодитоор оршин байхгүй) клуб, худгийн барилга, склад, талхны байрны барилга байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.2-д "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох; 4/ ашиглах хугацаа дуусаагүй боловч осол, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Төрийн өмч хөрөнгө шамшигдах, зориулалт бусаар ашиглагдах.

3.1.3 Өгсөн зөвлөмү: Бодитоор оршин байхгүй болон ашиглах боломжгүй болсон клуб, худгийн барилга, склад, талхны байрны барилгуудын асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандаж шийдвэрлүүлэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж, анхаарч ажиллана.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Ажилчдын зуслангийн байрны газрыг Сүхбаатар дүүргийн Засаг даргын захирамжаар нэр бүхий 38 иргэдийн өмчлөлд шилжүүлсэн байна. Өнөр бүл хүүхдийн төв нь дээрх шийдвэрийг хүчингүй болгуулахаар шүүхэд 2017 онд нэхэмжлэл гаргасан. Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 128/Ш332017/4172 тоот шийдвэрээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан ч газрын асуудлыг шийдвэрлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.8 дахь заалттай нийцэхгүй байна. Мөн Баянзүрх дүүргийн 17-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 5,145.0 мянган төгрөгийн өртөгтэй ногооны зоорийг 1979 онд Хүүхдийн төлөө фондын шийдвэрээр тус төвийн мэдэлд шилжүүлсэн ба уг зоорь ашиглалтын шаардлага хангахгүй болсон. Тус зоорь бүхий газрыг Баянзүрх дүүргийн Засаг даргын 2013 оны А/386 дугаар захирамжаар Баянзүрх дүүргийн засаг даргын тамгын газарт эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр Баянзүрх дүүргийн Засаг даргын 2013 оны А/386 дугаар захирамжийг хүчингүй болгосон. Газар эзэмших эрхийн гэрчилгээ нь тус төвийн нэр дээр гараагүй, газрын дахин үнэлгээ хийгдээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.1 дэхь заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл: Төрийн өмч хөрөнгө шамшигдах, зориулалт бусаар ашиглагдах.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Газрын асуудлыг холбогдох байгууллагуудад хандаж шийдвэрлүүлэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж, анхаарч ажиллана.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.3.1 Илрүүлэлт: Тус төвийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар шинэчлэгдсэн анхан шатны бүртгэлийн маягт, заавар Сангийн сайдын 2018 оны 100 тоот тушаалаар шинэчлэгдсэн нягтлан бодох бүртгэлийн маягтууд, Сангийн сайдын мөн оны 301 тоот тушаалаар шинэчлэгдсэн дотоод албан томилолтын зардлын хэмжээ зэргийг шинэчлэн тусгаагүй байна. Энэ нь УСНББОУС 3 *Нягтлан бодох бүртгэлийн бодлого, Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа*-тай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.3.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль, тогтоомжийн өөрчлөлтүүдийг оруулан шинэчлэх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 268,483,374.44 | 198,579,333.35 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | - |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | - | - |
| 33 | АВЛАГА | 2,966,315.08 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 135,850.00 | - |
| 335 | Бусад авлага | 2,830,465.08 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 2,830,465.08 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 265,517,059.36 | 198,579,333.35 |
| 351 | Түүхий эд материал | 18,703,630.00 | 3,266,720.75 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 17,000,940.00 | 3,030,000.00 |
| 35130 | Эм боох материал | 1,702,690.00 | 236,720.75 |
| 354 | Хангамжийн материал | 246,813,429.36 | 195,312,612.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,298,240.00 | 3,228,344.30 |
| 35420 | Аж ахуйн материал | 232,150.00 | 2,968,480.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 857,000.00 | 803,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 475,000.00 | 8,176,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 159,749,563.56 | 88,632,951.90 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 84,201,475.80 | 91,503,836.40 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 8,069,620,453.87 | 8,205,559,747.50 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 8,069,620,453.87 | 8,205,559,747.50 |
| 392 | Биет хөрөнгө | 7,590,374,977.38 | 7,726,322,187.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 7,062,610,320.00 | 7,566,610,103.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (299,318,116.73) | (466,835,499.53) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 296,689,884.00 | 284,998,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (151,858,050.46) | (178,999,166.42) |
| 39205 | Тоног төхөөрөмж (компьютер) | 652,595,672.55 | 658,724,783.55 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (270,645,500.79) | (376,576,886.15) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 251,651,654.00 | 214,078,514.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (98,358,784.15) | (84,508,715.19) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 152,009,451.00 | 152,009,451.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (10,031,080.04) | (48,207,924.76) |
| 39217 | Ном | 5,029,528.00 | 5,029,528.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 479,245,476.49 | 479,237,560.00 |
| 39301 | Програм хангамж | 4,447,000.00 | 4,447,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (4,439,083.51) | (4,447,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 479,237,560.00 | 479,237,560.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 8,338,103,828.31 | 8,404,139,080.85 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 227,470.70 | 20,591,031.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 227,470.70 | 20,591,031.00 |
| 413 | Өглөг | 227,470.70 | 20,591,031.00 |
| 4136 | Бусад өглөг | 227,470.70 | 20,591,031.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 227,470.70 | 16,887,883.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 3,703,148.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 8,337,876,357.61 | 8,383,548,049.85 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 8,337,876,357.61 | 8,383,548,049.85 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,746,814,042.00 | 1,746,814,042.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,746,814,042.00 | 1,746,814,042.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 3,692,468,383.06 | 3,753,254,541.30 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,692,468,383.06 | 3,707,582,849.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 45,671,692.24 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,898,593,932.55 | 2,883,479,466.55 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 8,338,103,828.31 | 8,404,139,080.85 |

4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|-------------------------|-------------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,960,614,496.01 | 2,582,677,963.00 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 61,323,346.01 | 119,769,783.00 |
| Нийтлэг татварын бус орлого | 61,302,946.01 | 119,769,783.00 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | 61,190,746.01 | 119,769,783.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 61,190,746.01 | 119,769,783.00 |
| Бусад орлого | 112,200.00 | - |
| Тусламжийн орлого | 20,400.00 | - |
| Хандив тусламж /дотоод/ | 20,400.00 | - |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,899,291,150.00 | 2,462,908,180.00 |
